



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/42/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар

1. Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/213

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020174

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Бат-Өлзий танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын хууль тогтоомжийг

харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ус цаг уур, орчны шинжилгээний албаны ажилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчин, ногоон хөгжлийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино".

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тус газар нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчны стандартыг мөрдүүлэх, УЦУОША, ИББЦГХЗ, Бөөнцагаан-Орог нуурын ай сав газрын захиргааны ерөнхий удирдлагаар хангах, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, байгаль хамгаалагчдыг сумдад томилон ажиллуулах зэрэг дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаагийн зэрэгцээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлд байгаль орчин, аялал жуулчлалын талаарх бодлого, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байгаль, орчин, аялал жуулчлал тогтвортой хөгжлийн талаар тусгагдсан асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 733318.5 мянган төгрөгөөс тооцон 14666.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 14666.4 мянган төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2722.6 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,916.61	74,194.00	-2,722.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00	00.00
33	АВЛАГА	732.31	00.00	-732.31
34	УРЬДЧИЛГАА	00.00	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	76,184.30	74,194.00	-1,990.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	470,745.45	465,260.02	-5,485.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	577,749.49	590,544.50	12,795.01
39	ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-107,004.04	-125,284.48	-18,280.44
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	547,662.05	539,454.02	-8,208.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	547,662.05	539,454.02	-8,208.03
51	Засгийн газрын хувь оролцоо	547,662.05	539,454.02	-8,208.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	547,662.05	539,454.02	-8,208.03

Бараа материалын дансны үлдэгдэл 1990.3 мянган төгрөгөөр буурсан ба 3225.0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авч тусгай зориулалтын материалын дансанд бүртгэсэн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 9831.9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө акталсан зэрэг томоохон өөрчлөлтүүд гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 32735.0 мянга, үнэ төлбөргүй 370.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 131 дүгээр тогтоолоор 20310.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 252228.7 мянган төгрөг болж 8208.0 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн 8208.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71413 кодтой нэг хөтөлбөрт зориулан 730942.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 727442.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 3500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 692592.8 мянган төгрөгийн санхүүжилт авч төсөвт байгууллагын өөрийн орлогоор 910.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 671397.4 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 692592.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 22105.4 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэн нь тайлант онд 6 байгаль хамгаалагчийн орон тоо дутуу ажилласантай холбоотой 20066.6 мянган төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 7500.0 мянган төгрөгийн санхүүжилт, даатгалын нөхөн төлбөр 654.6 мянга, 17000.0 мянган төгрөгийн хандив нийт 25154.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулж байгаль орчны хохирлын төлбөр 5181.0 мянган төгрөг орсныг Баян-Өндөр сумын хүү торгуулийн орлогын дансанд шилжүүлснийг дансны хуулгаар тулган баталгаажууллаа.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 20 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 27929.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 10129.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 17800.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 27929.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 10129.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө. Үүнд:

1. Тайлант онд цалингийн зардлаас ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтны шүүхэд хандсан нэхэмжлэлийн дагуу гаргасан шүүхийн шийдвэрийг үндэслэн 10129.5 мянган төгрөгийн нөхөн олговор, ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг төсвөөс төлсөн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн, "Эрх ба үүрэг", гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 17800.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.12.1. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Бат-Өлзийгийн 2019 оны 44 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн сургалт сурталчилгаа мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан Ц.Азжаргалд Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/ШШ2019/00677 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор, нийгмийн даатгалын шимтгэлд 2541.4 мянган төгрөг, 2018 оны 76 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн байгаль хамгаалагчаар ажиллаж байсан П.Батбаатард Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 111/ШШ2019/0014 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговор,

нийгмийн даатгалын шимтгэлд 7588.1 мянган төгрөг нийт 10129.5 мянган төгрөгийг тус байгууллагын цалингийн зардлаас олгосон байна. Энэхүү зөрчил нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалтыг зөрчсөн тул Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь заалтыг үндэслэн Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд албан шаардлага хүргүүлсэн тул хэрэгжилтийн талаар арга хэмжээ авсан эсэхийг тодруулж үзэх.

2.12.2. Тус байгууллага нь тайлант онд аймгийн Засаг даргын 2019 оны А/465 тоот захирамжийн дагуу 4 аж ахуйн нэгжээс 17000.0 мянган төгрөгийн хандив тусламж авч 21 аймгийн БОАЖГ-уудтай хамтран жил бүр уламжлал болгон зохин байгуулдаг "Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж тулгамдаж буй асуудал" сэдэвт зөвлөгөөний зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 -д заасан "Зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно" гэсэн заалттай нийцэхгүй тул дараагийн аудитаар хандив тусламж авч зарцуулсан эсэхийг авч үзэх, шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 27 мэдээлэлд байршуулснаас хойш дахин засвар хийснээс хугацаа хоцроосон төлөвт орж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	34	2	
5	Тухай бүр	8	96	73	23	
	Нийт	27	151	122	27	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Биет бус хөрөнгөд бүртгэлтэй 1570.0 мянган төгрөгийн программ хангамжаас 200.0 мянган төгрөгийн үнэтэй архивын программ, 600.0 мянган төгрөгийн үнэтэй санхүүгийн хуучин программ нь ашиглалтгүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Ашиглалтгүй биет бус хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Дансанд бүртгэлтэй программуудыг цаашид ашиглах боломжтой эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

- 2.1 **Илрүүлэлт:** Тус байгууллага нь тайлант онд аймгийн Засаг даргын 2019 оны А/465 тоот захирамжийн дагуу 4 аж ахуйн нэгжээс 17000.0 мянган төгрөгийн хандив тусламж авч 21 аймгийн БОАЖГ-уудтай хамтран жил бүр уламжлал болгон зохин байгуулдаг "Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж тулгамдаж буй асуудал" сэдэвт зөвлөгөөний зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д заасан "Зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- 2.2. **Эрсдэл:** Хандив тусламж авах эрхгүй байгууллага нь төрийн нэр барьж хандив тусламж авсан байх
- 2.3 **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалтыг хэрэгжүүлж хандив тусламж авч байгаа явдлыг зогсоож хандив тусламжийн орлогыг аймгийн орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлж байх.
- 2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,916,607.00	74,194,000.00
33	АВЛАГА	732,307.00	00.00
335	Бусад авлага	732,307.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	732,307.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	76,184,300.00	74,194,000.00
351	Түүхий эд материал	12,675,000.00	15,900,000.00
35110	Тусгай зориулалттай материал	12,675,000.00	15,900,000.00
354	Хангамжийн материал	63,209,300.00	57,994,000.00
35410	Бичиг хэргийн материал	358,800.00	592,500.00
35420	Аж ахуйн материал	28,617,500.00	23,168,500.00
35470	Бусад хангамжийн материал	34,233,000.00	34,233,000.00
35600	Мал амьтад	300,000.00	300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	470,745,446.77	465,260,019.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	470,745,446.77	465,260,019.14
392	Биет хөрөнгө	426,195,446.77	420,710,019.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	297,620,468.47	297,620,468.47
39203	Авто-тээврийн хэрэгсэл	151,868,890.00	154,568,890.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65,569,445.56	-68,222,778.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,013,564.95	75,422,574.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,612,695.62	-52,644,021.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,003,567.00	16,689,567.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,251,900.47	-2,847,678.23
39217	Ном	122,998.00	122,998.00
393	Биет бус хөрөнгө	44,550,000.00	44,550,000.00
39301	Програм хангамж	1,570,000.00	1,570,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,570,000.00	-1,570,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,550,000.00	44,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	547,662,053.77	539,454,019.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	547,662,053.77	539,454,019.14
51	Засгийн газрын хувь оролцоо	547,662,053.77	539,454,019.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	252,228,714.62	252,228,714.62
51101	Өмч: - төрийн	252,228,714.62	252,228,714.62
512	Хуримтлагдсан үр дүн	102,714,413.40	94,506,378.77
51210	Өмнөх үеийн үр дүн	102,714,413.40	102,714,413.40
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-8,208,034.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	192,718,925.75	192,718,925.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	547,662,053.77	539,454,019.14

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	662,042,400.00	725,110,465.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,530,000.00	2,182,045.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,530,000.00	2,182,045.00
120003	Торгууллын орлого	5,000,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,530,000.00	2,182,045.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжлэх	6,530,000.00	910,000.00
1200045	Үнө төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,272,045.00

**Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	650,512,400.00	722,928,420.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000,000.00	30,335,620.40
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдэс авсан хандив, тусламж	30,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	7,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	22,835,620.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	611,712,400.00	692,592,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	611,712,400.00	692,592,800.00
1330	Төсвийн захирагчдаас	3,800,000.00	00.00
133003	Хөрөнгийн	3,800,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	627,277,855.45	733,268,499.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	627,277,855.45	733,268,499.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	617,811,355.45	690,021,670.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,678,200.00	341,190,751.00
210101	Үндсэн цалин	265,165,200.00	284,656,751.00
210102	Нэмэгдэл	39,177,700.00	39,859,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,335,300.00	16,674,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,966,990.00	41,593,698.00
210201	Тэтгэврийн даатгал	37,966,990.00	41,593,698.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,224,860.00	16,420,171.00
210301	Гэрэл, цахилгаан	1,692,679.00	1,937,956.00
210302	Түлц, халаалт	13,918,301.00	13,862,663.00
210303	Цэвэр, бохир ус	613,880.00	619,552.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,980,940.00	19,403,203.00
210401	Бичиг хэрэг	2,206,240.00	3,539,700.00
210402	Тээвэр, шатахуун	23,603,400.00	12,375,445.00
210403	Шуудан, холбоо, интeрнeтийн төлбөр	2,315,800.00	2,186,658.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	555,500.00	941,400.00
2105	Нормативт зардал	26,200.00	5,280,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	26,200.00	5,280,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,974,200.00	7,890,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	50,000.00
210604	Урсгал засвар	3,974,200.00	7,840,500.00
2107	Томилголт, зочны зардал	5,050,200.00	8,581,500.00
210702	Дотоод албан томилолт	5,050,200.00	8,581,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	183,476,962.00	210,606,420.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,422,762.00	209,132,720.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	298,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	217,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	480,000.00
210807	Газрын төлбөр	14,200.00	178,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,432,803.45	39,055,427.55
210902	Хингэл үйлдвэрлэлийн даллага хийх	742,500.00	515,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,690,303.45	38,540,427.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,466,500.00	43,246,829.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,466,500.00	21,141,435.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,966,500.00	15,401,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	5,739,635.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	22,105,394.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	22,105,394.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	34,764,544.55	-8,158,034.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	50,000.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	50,000.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-50,000.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	34,764,544.55	-8,208,034.63

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	658,242,400.00	723,870,117.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,530,000.00	910,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,530,000.00	910,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,530,000.00	910,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,530,000.00	910,000.00



13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	646,712,400.00	722,960,117.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000,000.00	30,335,620.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000,000.00	7,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	22,835,620.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	611,712,400.00	692,592,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	611,712,400.00	692,592,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	31,697.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	31,697.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	658,242,400.00	691,135,117.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	658,242,400.00	691,135,117.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	625,875,559.00	647,856,591.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,958,200.00	341,268,163.00
210101	Үндсэн цалин	264,445,200.00	284,734,163.00
210102	Нэмэгдэл	39,177,700.00	39,859,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,335,300.00	16,674,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,526,497.00	40,811,179.00
210201	Тэтгэврийн даатгал	33,650,086.00	29,846,250.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,064,060.00	2,373,259.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,492,440.00	1,721,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	319,911.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,870,370.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,224,860.00	16,420,171.00
210301	Гэрэл, цахилгаан	1,692,679.00	1,937,956.00
210302	Түлш, халаалт	13,918,301.00	13,862,663.00
210303	Цэвэр, бохир ус	613,880.00	619,552.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,109,400.00	15,742,858.00
210401	Бичиг хэрэг	2,075,000.00	3,256,800.00
210402	Тээвэр, шатахуун	8,923,400.00	8,923,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,295,000.00	2,186,658.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэргэгчдийн устгал, ариутгал	300,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	516,000.00	1,016,000.00
2105	Нормативт зардал	1,861,200.00	3,225,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,861,200.00	3,225,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,852,900.00	5,850,000.00
210601	Багаж, техник, хэргэсэл	2,302,900.00	500,000.00
210602	Тавилга	5,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,550,000.00	5,350,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,050,200.00	8,581,500.00
210702	Догоод албан томилолт	5,050,200.00	8,581,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	213,343,810.00	215,442,720.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	212,537,110.00	214,449,020.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	298,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	217,000.00
210807	Газрын төлбөр	14,200.00	178,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,948,492.00	515,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,205,992.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	742,500.00	515,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,366,841.00	43,278,526.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,466,500.00	21,173,132.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	31,697.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,966,500.00	15,401,800.00

**Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	5,739,635.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,900,341.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,900,341.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	22,105,394.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	22,105,394.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	32,735,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	32,735,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	32,735,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	32,735,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	32,735,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-32,735,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	102,714,413.40	547,662,053.77
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	102,714,413.40	547,662,053.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	102,714,413.40	547,662,053.77
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,208,034.63	-8,208,034.63
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,228,714.62	192,718,925.75	94,506,378.77	539,454,019.14

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэж		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	730,942,800.00	671,397,406.00	59545394.00	91.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	730,942,800.00	671,397,406.00	59545394.00	91.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,541,000.00	650,255,971.00	59285029.00	91.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	356,040,800.00	341,268,163.00	14772637.00	95.9
210101	Үндсэн цалин	299,482,900.00	284,734,163.00	14748737.00	95.1
210102	Нэмэгдэл	39,859,600.00	39,859,600.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,698,300.00	16,674,400.00	23900.00	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,105,100.00	40,811,179.00	5293921.00	88.5
210201	Тэтгэврийн даатгал	31,351,100.00	29,846,250.00	1504850.00	95.2
210202	Тэтгэмжийн даатгал	3,688,800.00	2,373,259.00	1315541.00	64.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,950,800.00	1,721,300.00	1229500.00	58.3
210204	Ажилгүйдлийн даатгал	738,000.00	00.00	738000.00	00.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,376,400.00	6,870,370.00	506030.00	93.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,878,300.00	16,420,171.00	1458129.00	91.8
210301	Гэрэл, цахилгаан	3,042,200.00	1,937,956.00	1104244.00	63.7
210302	Түлш, халаалт	14,098,300.00	13,862,663.00	235637.00	98.3
210303	Цэвэр, бохир ус	737,800.00	619,552.00	118248.00	84.0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,851,200.00	15,742,858.00	108342.00	99.3
210401	Бичиг хэрэг	3,256,800.00	3,256,800.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	8,923,400.00	8,923,400.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, нигерүгийн төлбөр	2,295,000.00	2,186,658.00	108342.00	95.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,000.00	1,016,000.00	0.00	100.0

**Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2105	Нормативт зардал	3,230,000.00	3,225,000.00	5000.00	99.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,230,000.00	3,225,000.00	5000.00	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,085,000.00	17,085,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,735,000.00	1,735,000.00	0.00	100.0
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	5,350,000.00	5,350,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	8,585,400.00	8,581,500.00	3900.00	100.0
210702	Дотоод албан томилолт	8,585,400.00	8,581,500.00	3900.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,022,700.00	206,607,100.00	37415600.00	84.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	243,015,000.00	205,613,400.00	37401600.00	84.6
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	298,500.00	298,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оюушлогоо	231,000.00	217,000.00	14000.00	93.9
210807	Газрын төлбөр	178,200.00	178,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	742500.00	515000.00	227500.00	69.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	742,500.00	515,000.00	227,500.00	69.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21401800.00	21141435.00	260365.00	98.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,401,800.00	21,141,435.00	260,365.00	98.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нөг удаагийн мөнгөн тэтгэмж	15,401,800.00	15,401,800.00	0.00	100.0
213209	Нөг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	5,739,635.00	260,365.00	95.7
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	730,942,800.00	693,502,800.00	37440000.00	94.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	727,442,800.00	692,592,800.00	34850000.00	95.2
132001	Орон нутгийн төсвөөс	727,442,800.00	692,592,800.00	34,850,000.00	95.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,500,000.00	910,000.00	2590000.00	26.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	910,000.00	2,590,000.00	26.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	39.00	6.00	86.7
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	32.00	6.00	84.2
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35000000.00	30,335,620.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35000000.00	30,335,620.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35000000.00	30,335,620.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35000000.00	30,335,620.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35000000.00	30,335,620.40
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35000000.00	30,335,620.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35000000.00	30,335,620.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35000000.00	7,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		22,835,620.40

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР

Огноо: 2020.02.27

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.02.27

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27